



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/897

Улаанбаатар хот

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2025-2028 оны стратеги төлөвлөгөөг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга)-т даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2 жил тутамд Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга)-т, тайланг холбогдох журмын дагуу үнэлж, тухайн жилийн II улиралд багтаан танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Буяннэмэх)-д үүрэг болгосугай.



Б.БАТБААТАР



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөгөөг баталсан:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД



(гарын үсэг)

Б.БАТБААТАР

.....
(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан:
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ,
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

.....
(гарын үсэг)

Э.БАТТУЛГА

.....
(огноо)

Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн
сайдын 2025 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 18.7 дугаар тушаалын хавсралт

**Цаг уур, орчны шинжилгээний газрын
2025-2028 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга**

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	3-4
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	4-5
Бүлэг 3. Алсын хараа	5
Бүлэг 4. Эрхэм зорилго	5
Бүлэг 5. Орчны шинжилгээ	5-18
Бүлэг 6. Стратегийн зорилго	18
Бүлэг 7. Стратегийн зорилт, арга зам, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хүрэх үр дүн.....	19-27
Бүлэг 8. Стратегийн зорилго ба Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын байгууллагын бүтцийн уялдаа, зураглал.....	28-30
Бүлэг 9. Хавсралт	31

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хэрэгцээ, шаардлага

Монгол орны уур амьсгал, байгаль, цаг уурын тааламжтай нөхцөлийг бүрэн дүүрэн ашиглах, цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэмжлүүлж, эрсдэлийг багасгах, улмаар улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр Монгол оронд мөстөл хайлах, мөнх цэвдэг гэсэх, гүний ус багасах, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, аадар тунадас, үер зэрэг цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэж, хуурайшилт, цөлжилт зэрэг орчны доройтол эрчимжин, улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл жилээс жилд нэмэгдэж байна.

Монгол орны аюулгүй байдал, эдийн засгийн үндэс болсон бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, уул уурхай, аялал жуулчлал зэрэг салбарууд нь байгаль цаг агаарын эрхшээлд оршсоор байна.

Хүн амын төвлөрөл, цаг агаарын онцлогоос шалтгаалан Улаанбаатар хот, бусад томоохон хотуудын агаар, ус, хөрсний бохирдол нэмэгдэж, иргэдийн амьдрах орчин, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл улам ихэссээр байна.

Монгол орны байгаль экологид гарч буй болон цаашид гарах өөрчлөлтийг тодорхойлох, түүнд зохицон амьдрах чадавх, бололцоогоо нэмэгдүүлэх, сөрөг үр дагаврыг сааруулах арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх, холбоо мэдээлэл, техник технологийг шинэчлэх, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжийн дагуу гишүүн орнууд 2020 оноос өмнө мөнгөн уст хэмжлийн багажийн хэрэглээг бүрэн зогсоож, ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд автомат болон зайнаас хэмжих техник, технологийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай болсон.

1.2 Бодлого, эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталж, уг баримт бичигтэй нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, 2024 оны 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталж, урт, богино хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Салбарын ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөнд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт, богино хугацааны бодлогууд, салбарын бусад бодлогын баримт бичгүүд, Олон Улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, стратегийг боловсруулж тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасныг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг удирдлага болгон Ус цаг уур,

орчны хяналт шинжилгээний салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-г баримталсан.

Стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын өмнөх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Ус цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр дэвшүүлсэн зорилтын биелэлтэд дүн шинжилгээ хийж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын “Хүн төвт” хөгжлийн төлөвлөгөөний хүрэх түвшин баримтлан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үндсэн чиг үүргийн хүрээнд 8 зорилт, 61 арга хэмжээг ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлнэ. Дээрх зорилт, стратеги арга хэмжээг хэрэгжүүлэхдээ салбарын байгууллагуудын боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангахаар тусгаж төлөвлөсөн болно.

Хоёр. Мандатын шинжилгээ

Мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын шууд хамаарах 16 хууль болон бусад олон улсын гэрээ конвенц, төрийн алба, яам, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон салбарын бусад байгууллагуудад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзсэн.

Мандатын шинжилгээний үр дүнд 1 ерөнхий чиг үүрэг, 3 үндсэн чиг үүрэг, 11 дэд чиг үүргийг тодорхойлж, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэсэн.

Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		44
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	15
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	29
Ерөнхий чиг үүрэг-1 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах.	1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилт, тасралтгүй ажиллагааг хангах	ЦУОШГ, УЦУОСМХ, НЦУТ, БОХТЛ, Аймаг, хотын УЦУОШТ-үүд
	2. Сүлжээг өргөтгөх, техник, технологийн шинэчлэлийг төлөвлөж хэрэгжүүлэх	
	3. Дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагааг хангах	
	4. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах	
	5. Ус, цаг уур, орчны мэдээллийн баримтын төрийн архивыг эрхлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах	
ҮЧҮ-2:	6. Ус, цаг агаарын түүхэн, бодит болон урьдчилсан мэдээ, орчны төлөв байдлын мэдээллээр үйлчлэх	ЦУОШГ,

Ус цаг уур, орчны мэдээ мэдээллээр хангах.	7. Ус, цаг агаар, уур амьсгалын /ган, зуд/ гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх	УЦУОСМХ, НЦУТ БОХТЛ, Аймаг, хотын УЦУОШТ-үүд
	8. Тусгай хэрэгцээний мэдээгээр нийгэм, эдийн засгийн салбар /Нисэх, Төмөр зам, Автозам, ХАА, Эрчим хүч гэх мэт/-уудыг хангах	
	9. Цаг агаарт зориудаар нөлөөлөх	
ҮЧҮ-3: Ус цаг уур, орчны эрдэм шинжилгээ, судалгаа хийх.	10. Ус, цаг агаар, хөдөө аж ахуй, орчны төлөв байдал, уур амьсгалын нөөц, түүний өөрчлөлт, нөлөөллийн судалгаа хийх	ЦУОШГ, УЦУОСМХ Аймаг, хотын УЦУОШТ-үүд
	11. Тоон загварчлал, шинэ арга зүй, инноваци, технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	

Гурав. Алсын хараа

Ус цаг уур, орчны үйлчилгээний чанараар Азийн тэргүүлэгч байгууллагуудын нэг болно.

Дөрөв. Эрхэм зорилго

Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ, судалгаа хийж, бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино.

Тав. Орчны шинжилгээ

5.1 Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын өнөөгийн байдал

Агентлаг нь цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээг тасралтгүй найдвартай ажиллуулж, ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдлын бодит болон урьдчилсан, урьдчилан сэргийлэх, тусгай хэрэгцээний мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй хангах ажлыг зохион байгуулж, төр, иргэд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, нийгмийн хэрэгцээнд тулгуурласан ус цаг уур, орчны мэдээ мэдээллээр мэргэжлийн түвшинд чанартай, шуурхай үйлчилж байна.

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.13-д "Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, таваас доошгүй байршилд радарын станц байгуулна", Монгол улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.3-д "Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах", Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 3.4.2.6.Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирлын эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлнэ, . гэж тус тус туссан.

Өнөөдрийн байдлаар Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 26 байгууллагад нийт 1722 албан хаагч ажиллаж байна. Үүнээс 1477 албан хаагч аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвд, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд 89 албан хаагч, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид 33 албан хаагч, Нислэгийн цаг уурын төвд 53, Цаг уур, орчны шинжилгээний газарт 70 албан хаагч албан хаагч ажиллаж байна.

Төрийн захиргааны албан тушаалтан 34, төрийн үйлчилгээний шинжлэх ухааны ажилтан 31, төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалтан 1583, нийтлэг үйлчилгээний албан тушаалтан 31, төрийн үйлчилгээний мэдээллийн технологийн албан тушаалтан 1 байгаа бөгөөд удирдах албан тушаалтан 34, гүйцэтгэх албан тушаалтан 1443 ажиллаж байна.

2025 оны байдлаар төвийн 22 байгууллагаас 3 нь сайн байртай, шинээр баригдсан, 3 конторын байр 2026 онд шинээр ашиглалтад орно, 6-8 төвийн байр хэвийн, их засвар хийсэн, 8 барилга насжилт өндөртэй дүгнэлт гарсан зураг, төсөв хийгдэж төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих шаардлагатай.

Өртөөний барилгын хувьд 68 хувь нь 2010 оноос хойш баригдсан байртай 2025 онд 10 өртөөний байр шинээр орно, 25 байр нь 1964-1999 оны байртай, насжилт өндөр, дүгнэлттэй, үүнээс 4 өртөө байргүй, 2024 онд бүх өртөө ариун цэврийн өрөөтэй болсон, харуулын байртай газар байхгүй энэ жил анх удаа харуулын байртай болсон.

5.1.1 Ус цаг уурын улсын сүлжээ

Монгол Улсын нутаг дэвсгэрт цаг уурын тогтмол ажиглалт анх 1924 онд хийгдэж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээнд 318 цаг уурын өртөө, харуул (300 сум, 11 баг, тосгон, 7 дүүрэг, хороо), агаар мандлын дээд давхаргыг судлах 5 станц, шар шороон шуурганы 2 станц, лидарын 3 станц, хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах 2 станц, доплерын радарын 2 станц, ус судлалын 155 харуул, орчны хяналт шинжилгээний 22 лаборатори, агаарын чанарын хяналтын 40 станц, хүчиллэг тунадасны 2 станц, усны чанарын 194, хөрсний чанарын 400, бэлчээрийн төлөв байдлын 1550 гаруй цэгт тогтмол ажиглалт, хэмжилт хийж байна.

Ус, цаг уурын өртөө, харуулыг автомат станцаар 100 хувь хангаж, радарын сүлжээ бий болгон, суперкомпьютерын хүчин чадлыг нэмэгдүүлснээр ус, цаг агаарын болон агаарын бохирдлын бүх төрлийн урьдчилсан мэдээний таарцыг 0.2-10 хүртэл хувиар нэмэгдүүлж, гамшигт үзэгдлийг эртнээс сэрэмжлүүлж, эрсдэлийг бодитоор бууруулах, нислэгийн цаг уурын үйлчилгээг оновчтой үр ашигтай болгох боломжтой болох юм.

Цаг уурын нийт өртөө, харуулын 120 нь автомат станцгүй байгаагаас цаг уурын хэмжилтийг механик, мөнгөн уст багажаар хийсээр байгаа нь Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын хэрэгжилт болон Дэлхийн цаг уурын байгууллагын мөнгөн уст хэмжих хэрэгсэл ашиглахыг зогсоох тухай зөвлөмжийн хэрэгжилтийг зөрчиж байна. Мөн мөнгөн уст хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд зогссон, мөнгөн усыг хилээр нэвтрүүлэхэд хязгаарлалт тогтоосон зэрэг шалтгааны улмаас хэмжих хэрэгслийн хомсдол үүсэж, цаг уурын анхан шатны мэдээний цуваа тасарч, уур амьсгалын өөрчлөлт, хэт халалт, хөрөлтийг хэмжихгүй өнгөрөх, судалгаа, шинжилгээний ажил хийх боломжгүй болох нөхцөл бий болж, урьдчилсан мэдээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

Гадаргын ус судлалын 155 харуул дээр хийдэг горимын хэмжилтүүд бүгд гар аргаар хэмжилтийг гүйцэтгэж байгаа нь Монгол орны гадаргын усны горим нөөцийг зөв тооцоолох, ард иргэдийг үер усны аюулаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна. 1943 оноос хойш анх удаа гадаргын усны 17 харуулыг автоматжуулах ажил хийгдэж эхлээд туршилтын хугацаанд явж байна.

Цаг агаарын зарим аюултай үзэгдлийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор анх 1978 онд Морин-Ууланд Зөвлөлт Холбоот Улсын МРЛ-2 радиолокаторын станцыг байгуулсан ба 1999 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Доплерийн эффект бүхий С-төрлийн радараар сайжруулан сольсон байдаг. Тус радар нь 26 дэх жилдээ тасралтгүй ажиллаж байгаа хэдий ч техник, технологийн хувьд хуучирч, сэлбэгийн нөөц дууссанаас сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа нь доголдох болсон. 2022 онд Улаанбаатар хотын хойд хэсэгт, Чингэлтэй уулын оройд БНХАУ-д үйлдвэрлэсэн Доплерийн эффект бүхий Х төрлийн радар суурилуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд орчны чанарын шинжилгээг хийж, үнэлгээ, дүгнэлтийг бодлого боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигладаг.

Байгаль орчны шинжилгээний лабораториуд нь агаар, ус, хөрсний чанар, хаягдал усанд шинжилгээ хийдэг хэдий ч бохирдлын цөөхөн үзүүлэлтээр хянаж байгаа нь орчны бохирдлыг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд байгалийн нөөц баялагт тулгуурласан үйлдвэржилт эрчимжиж, аж үйлдвэрлэлийн гол түшиц газар болон хөгжиж байгаа боловч төлөвлөлтгүй тэлэлт, хог хаягдлын муу менежмент, химийн бодисын хууль бус хэрэглээний улмаас хортой, аюултай хаягдал хуримтлагдах, үйлдвэрлэлээс гарч байгаа хаягдал бохир усан дахь органик бохирдуулагч бодис зэрэг нь орчны бохирдлыг үүсгэж улмаар орчны чанарыг доройтуулж байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Иймд Байгаль орчны шинжилгээний лабораторийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд өргөжүүлж, агаар, ус, хөрсөн дэх хүнд металл, органик болон органик биш бохирдуулах бодис, пестицид зэрэг бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлж, бодит дүн мэдээллийг шуурхай гарган хүрээлэн байгаа орчны төлөв байдлыг тодорхойлох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Байгаль орчны шинжилгээний лабораторийг бүсийн төв лаборатори болгон өргөжүүлж, орчин үеийн шинэ багаж тоног төхөөрөмжөөр тоноглон, инженер техникийн ажилтнуудын чадавхыг сайжруулснаар одоо тодорхойлох боломжгүй байгаа агаар, ус, хөрсөн дэх хүний эрүүл мэндэд шууд нөлөөлөх, хавдрын өвчлөл үүсгэх, гений өөрчлөлтийг бий болгох эрсдэлтэй олон төрлийн хорт органик нэгдлийг 30 үзүүлэлтээр, хүнд металлыг 40 үзүүлэлтээр өндөр нарийвчлалтай тодорхойлж, иргэд, олон нийтийг хүрээлэн байгаа орчны чанарын нарийвчлал өндөртэй, бодит мэдээллээр хангах боломжтой болно.

5.1.2 Салбарын бодлого, хууль, тогтоомж, түүний хэрэгжилт

Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Ус, Цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд хэрэгжиж байна.

Монгол Алсын хараа-2050" хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж ажиллаж байна.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /цаашид "УЦУОХШТХ" гэх/ нь 1997 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, 2003, 2015, 2017, 2018, 2020, 2022 онуудад тус бүр нэмэлт, өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасан.


Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 87-д "Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орны хувьд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц зэрэг олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, хуулийн нэр томьёог шинээр тодорхойлох, ус, цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний байршил, өртөө харуулын шинжилгээний талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах, ус, цаг уур, орчны хяналт

шинжилгээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулахад өөрчлөлт оруулах, мэдээ ашиглалт, дамжуулалт, архив, мэдээллийн сан, мэдээний үйлчилгээ, нэр төрөл, мэдээ, мэдээллээр хэрэглэгчийг хангах, цаг агаарын аюулт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бэхжүүлэх, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдын нийгмийн баталгааны талаарх зохицуулалтыг тусгах” агуулга бүхий Ус, цаг уур, орчны шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын 3.2.3-т “захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол” гэж зааснаар Цаг уур, орчны шинжилгээний газрын зүгээс дээрх аргачлалын 3.2.2-т “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалд нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол” гэсний дагуу энэхүү нөхцөл байдал үүссэн тухай үндэслэл бүхий зарчмын тодорхой саналууд гаргасан байна. Иймд дээрх шалтгаануудын үүднээс УЦУОХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

5.1.3. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт

Цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн санхүүжилтийн хэмжээ 2020-2025 онуудад салбарын техникийн шинэчлэлт, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөц болон орчны мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах бодлоготой уялдан өссөн үзүүлэлттэй байна. Төр, засгийн шийдвэрээр цалингийн өсөлт, цаг уурын орон нутгийн албан хаагчдад зэрэг дэв, орон нутагт ажилласны нэмэгдэл голлох өсөлтийг эзэлж байна.



2020 онд 36.71 тэрбум байсан батлагдсан хөрөнгө оруулалтын төсөв 2022 онд 929.8, 2023 онд 332.66 тэрбум болж хэлбэлзсэн боловч 2024 онд 26,077.20 тэрбум хүртэл огцом өссөн нь салбарын хөгжлийн стратегийн хүрээнд хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээнүүд хэрэгжиж, салбарын 100 жилийн түүхт ойн хүрээнд хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин 2025 онд нийт төсөв 3,107.99 тэрбум болж батлагдсан бөгөөд жилийн дундах тодотголоор урсгал төсөв 74.39 тэрбум болж буурч, цалин, урсгал төсөв оны эхний батлагдсанаас 10,5 хувиар буурч төсвийн зохицуулалт хийгдсэн.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт 2020 онд 3.36 тэрбум байсан бол 2022 онд 897.4 тэрбум хүртэл нэмэгдэж, 2024 онд 26,000.00 тэрбум, 2025 онд 3,027.50 тэрбум болсон нь салбарын хэмжээнд дэд бүтэц, урьдчилан мэдээлэх системийн шинэчлэл, ажиглалтын

сүлжээг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг урт хугацааны хөрөнгө оруулалтын төслүүдийг эхлүүлсэнтэй шууд холбоотой.

Урсгал зардал 2020 онд 33.35 тэрбум байсан бол 2024 онд 77.20 тэрбум, 2025 онд 80.49 тэрбум болж өссөн нь байнгын үйл ажиллагааны зардал, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, цаг уурын мэдээллийн чанар, техникийн хэвийн ажиллагааг хангах зардал нэмэгдсэнтэй холбоотой. Урсгал зардлын өсөлт нь иргэд, олон нийтэд цаг агаар, уур амьсгалын мэдээллийг найдвартай, шуурхай хүргэх нөхцөлийг сайжруулахад чухал нөлөөтэй.


5.2. Ус цаг уур, орчны мэдээлэл, үйлчилгээ

5.2.1. Цаг агаарын урьдчилсан мэдээ

Цаг уур, орчны шинжилгээний газрын Урьдчилан мэдээлэх хэлтсээс 2021-2024 онд 28 хот, суурингаар 1-5 хоногийн урьдчилсан мэдээ, ус, цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг бичиж олон нийтийн суваг болон холбогдох яам, газруудад цаг тухайд нь хүргэж ажилласан болно. Мэдээ бүрийн таарцыг дараах хүснэгт болон зурагт үзүүлэв. Жил бүрийн цаг агаарын тогтвортой байдлаас мэдээлэл үйлчилгээний ажлын чанар ихээхэн хамаардаг.

Он	1 хоногийн урьдчилсан мэдээний таарц (%)	Сэрэмжлүүлэх болон Урьдчилан сэргийлэх мэдээ		1-5 хоногийн урьдчилсан мэдээний дундаж таарц (%)
		чанар (%)	онч (%)	
2021	92.5	71.9	88.8	87.8
2022	93.2	62.9	81.1	88.9
2023	92.7	68.1	82.6	87.3
2024	92.4	72.2	83.3	87.9

1 болон 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц, %



Тухайн онуудын мэдээний таарц, онч мөн анхааруулах мэдээ, ус, цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээний гаргасан тоог дараах хүснэгтээр харуулав.

Он	Анхааруулга мэдээний тоо	Сэрэмжлүүлэх мэдээний тоо	Урьдчилан сэргийлэх мэдээний тоо
2021	983	160	8
2022	819	86	4
2023	690	147	12
2024	983	114	16

5.2.2. Орчны хяналт шинжилгээ

5.2.2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль журмын хүрээнд орчны чанарын хяналт шинжилгээг хийж, үнэлгээ, дүгнэлтийг бодлого боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигладаг билээ.

Монгол улсын хэмжээнд Байгаль орчны төлөв байдлыг тодорхойлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгаль орчны шинжилгээний лаборатори нь анх 1976 онд Улаанбаатар хотод байгуулагдсанаас хойш сүлжээгээ өргөжүүлснээр улсын сүлжээнд байгаль орчны шинжилгээний 22 лаборатори агаар, ус, хөрсний чанарын төлөв байдал, цацрагийн түвшин, цөлжилтийн төлөв байдлыг тодорхойлох хяналт шинжилгээг хийж байна. Үүнд:

Агаарын чанарыг улсын хэмжээнд 39 цэгт, үүнээс Улаанбаатар хотод 13 цэгт, орон нутагт аймгийн төв томоохон суурин газар 24 цэгт, цацрагийн түвшнийг 37 цэгт, гадаргын усны чанарыг 193 цэгт, хөрсний чанарыг 500 орчим цэгт, цацрагийн түвшинг 37 цэгт, цөлжилтийг үнэлэх хөрсний чанарын анхан шатны хяналтыг 1550 цэгт 2012 оноос 5 жилд 1 удаа тус тус хянаж байна.

Агаарын чанарыг Улаанбаатар хотод зөвхөн түгээмэл тархалттай 6 бохирдуулах бодис, орон нутагт 3-6 бохирдуулах бодисыг автоматаар тасралтгүй тодорхойлж, бусад бохирдуулах бодисыг тодорхойлж чадахгүй байна.

Улсын хэмжээнд 100-4200кВТ хүчин чадалтай зуух 1117, үүнээс орон нутагт 775 зуух 797742 тн нүүрс, Улаанбаатар хотод 342 зуух 63024 тн түүхий нүүрс, 72154 тн мидлинг буюу угаасан нүүрс, 1064 тн сайжруулсан түлш хэрэглэсэн байна.

Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр агаар бохирдуулах бодисын 2024 оны жилийн дундаж агууламжийг Агаарын чанар. MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 1.1 дахин их, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 1.1 дахин их, PM_{2,5} нарийн тоосонцорын жилийн дундаж агууламж 1.8 дахин их, PM₁₀ тоосонцрын жилийн дундаж агууламж 1.8 дахин тус тус их байна. 2024 оны жилийн дундаж агууламжийг 2023 оны жилийн дундаж агууламжтай харьцуулахад хүхэрлэг хийн агууламж 1 мкг/м³-ээр бага, харин PM_{2.5} тоосонцрын жилийн дундаж агууламж 4 мкг/м³-ээр, PM₁₀ тоосонцрын жилийн дундаж агууламж 6 мкг/м³, азотын давхар исэл 6 мкг/м³-ээр тус тус их байна

Агаарын чанарын индексийн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад "Цэвэр" түвшин 6 %-иар буурсан, "Хэвийн" түвшин 1%-иар ихэссэн, "Бага бохирдолтой" түвшин 3%-иар багассан, "Бохирдолтой" түвшин өмнөх жилийн түвшинд, "Их бохирдолтой" түвшин 0.6%-иар ихэссэн, "Маш их бохирдолтой" түвшин 0.1%-иар багассан байна.

Орон нутаг дахь аймгийн төв болон томоохон суурин газрын агаарын чанарыг нийт 26 цэгт тодорхойлж, агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламжийг Агаарын чанар. MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж Говь-Алтай, Баянхонгор аймагт 2-6 мкг/м³-ээр тус тус их, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж Орхон аймагт 72 мкг/м³-ээр, Хөвсгөл аймагт 6 мкг/м³-ээр, Өвөрхангай аймагт 13 мкг/м³-ээр тус тус их, PM₁₀ тоосонцорын жилийн дундаж агууламж Дархан-Уул аймаг, Өмнөговь аймаг, Завхан аймаг, Сэлэнгэ аймаг, Зүүнхараа аймаг, Архангай аймагт 1-13 мкг/м³-ээр их, PM_{2,5} нарийн тоосонцорын жилийн дундаж агууламж Баянхонгор аймагт 31 мкг/м³-ээр, Говь-Алтай аймагт 47 мкг/м³-ээр, Дорнод аймагт 15 мкг/м³-ээр, Өмнөговь аймагт мкг/м³-ээр, Булган аймагт 18 мкг/м³-ээр, Дархан-Уул аймагт 57 мкг/м³-ээр, Төв аймагт 52 мкг/м³-ээр, Хөвсгөл аймагт 115 мкг/м³-ээр, Зүүн хараад 22 мкг/м³-ээр, Архангай аймагт 23 мкг/м³-ээр, Дундговь аймагт аймагт 1 мкг/м³-ээр тус тус их байсан байна.

Гадаргын усны чанарыг улсын хэмжээнд 94 гол, мөрөн 19 нуурын усыг 193 цэгт сард 1 удаа 7-15 орчим бохирдуулах бодис болох гол ион, биогений үзүүлэлтүүдээр тодорхойлж, бусад бохирдуулах бодисыг тодорхойлж чадахгүй байна. Гадаргын усны хяналт шинжилгээний дүнгээр "Бага бохирдолтой" ангилалд Туул-Сонгино дээд орчимд, Уртбулаг (Орхон аймаг), Зэгстэй голууд, "Бохирдолтой" ангилалд Хангал гол (Орхон аймаг), "Маш бохир" ангилалд Туул голын Сонгино доод, Шувуун фабрика, Хадан хясаа, Алтанбулаг орчимд, Хиагт гол (Сэлэнгэ аймаг) зэрэг голууд байна.

Хөрсний чанарыг улсын хэмжээнд 500 гаруй цэгт, үүнээс Улаанбаатар хотод 100 гаруй цэгт агрохими, хүнд металлын 7 бохирдуулах бодисоор тодорхойлж, нянгийн бохирдол болон бусад бохирдуулах бодисыг тодорхойлж чадахгүй байна.

Хөрсний чанарыг тодорхойлсон хяналт шинжилгээний дүнгээр Улаанбаатар хотод хөрсөн дэх хүнд металлын агууламж нийт хэмжилтийн 3.7 %- нь Хөрсний чанар. MNS5850:2019 стандартаас их буюу цайрын агууламж Халдвартын эмнэлэг орчимд 1.9 дахин, Кино үйлдвэр орчимд 4.4 дахин, Харгиа орчимд 1.1 дахин тус тус их, хар тугалганы агууламж Цагаан чулуутын хогийн цэг орчимд 1.4 дахин их, хромын агууламж Харгиа орчимд 3.2 дахин их байсан байна.

Орон нутагт хийсэн хяналт шинжилгээний дүнг Хөрсний чанар. MNS5850:2019 стандарттай харьцуулахад Говь-Алтай аймгийн "Цаг уур" орчимд хар тугалганы агууламж 1.9 дахин их, "ТМ сургууль", "I арван жилийн сургууль", "Махан зоорь", "Шинэ алтай зах" орчимд хромын агууламж 1.2-2 дахин их, Завхан аймгийн "Цэргийн анги" орчимд цайрын агууламж 1.1 дахин их, Орхон аймгийн "Трактортой хөшөө", "ГОК-ийн 10-р цэцэрлэг", "ТЭЦ", "Төмөр зам", "ЕБС-ийн 3-р сургууль", "Дэнжийн гадаад хэлний сургууль", "Солонго зах" "Эрдмийн харуулын байр" орчимд цайрын агууламж 1.1-9.4 дахин их, Увс аймгийн "Хүнсний зах", "Дулаан арьс шир" орчимд цайрын агууламж 1.1-2.1 дахин их, Ховд аймгийн "Бадамлах дөл дулааны цахилгаан станц" орчимд кадмийн агууламж 1.8 дахин их, хар тугалганы агууламж 1.3 дахин их, цайрын агууламж 2.5 дахин тус тус их байсан байна.

Цацрагийн түвшний хяналтыг 37 цэгт хийсэн дүнгээр гамма цацрагийн тунгийн чадлын дундаж нь улсын хэмжээнд 2024 онд агаарт 0.09-0.13 мкЗв/цаг, хөрсөнд 0.09-0.14 мкЗв/цаг байсан нь байгалийн фоны дэвсгэр түвшний хэвийн утгаас хэтрээгүй байна.

Хяналт шинжилгээний дүнгээр байгаль орчныг бохирдол жилээс жилд нэмэгдэж, орчны чанар доройтон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Иймд орчны бохирдлыг өргөн хүрээнд хянах, бохирдлоос сэргийлэх, бууруулах арга хэмжээ авахад хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлэх, бохирдуулах бодисын үзүүлэлтийн тоо, чанарыг өндөр түвшинд тодорхойлж, дүгнэлт гаргах нь нэн тэргүүний чухал асуудал болоод байна.

Байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход байгаль орчныг бохирдуулж буй цөөн хэдэн бохирдуулах бодисыг тодорхойлж байгаа нь Байгаль орчны хяналт шинжилгээний лабораториудад ашиглаж байгаа багаж төхөөрөмж өнөөгийн түвшнээс хоцорч, бохирдуулах бодисыг тодорхойлох тоо хэмжээ, нэр төрөл, цар хүрээ хангалтгүй байгаа нь үнэлэлт дүгнэлтийг бүрэн өгч чадахгүй, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, төрийн байгууллагын эрэлт хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй байна.

Иймд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бүсийн төвийн лабораторийг бий болгон орчин үеийн өндөр технологи бүхий нарийн хэмжлийн багаж тоног төхөөрөмжөөр тоноглон тодорхойлж чадахгүй байгаа олон төрлийн хорт органик, органик биш нэгдэл, хүнд металл, нянгийн бохирдлыг өндөр нарийвчлалтай тодорхойлох, улмаар орчны бохирдолд нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан үр дагаврыг цаг алдалгүй нарийн тогтоох, орчны бохирдлоос сэргийлэх, бууруулахад үнэлэлт дүгнэлт өгөх, бодит дүн мэдээллийг шуурхай гаргах, хүрээлэн байгаа орчны төлөв байдлыг тодорхойлох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

5.2.3. Архив, мэдээллийн сан


Тус газрын архив, мэдээллийн сангийн хэлтэс нь улсын хэмжээнд “Архив, албан хэрэг хөтлөлийн тухай хууль” зааснаар төрийн төрөлжсөн архивын үүрэг хүлээн ажилладаг бөгөөд төв орон нутгийн 25 байгууллагын хөмрөг үүрсэгч байгууллагын шинжилгээний архивыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, цахим архив бүрдүүлэх, мэдээ баримтын бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт, хамгаалалтыг удирдан зохион байгуулж байна. Төрийн архивын цаасан баримтын төрөл нь Цаг уур-уур амьсгал судлалын баримтын хөмрөг, Нарны цацраг судлалын баримтын хөмрөг, Агаарын дээд давхарга судлалын баримтын хөмрөг, Хөдөө аж ахуйн цар уур судлалын баримтын хөмрөг, Ус судлалын баримтын хөмрөг, Орчны шинжилгээний баримтын хөмрөг, Цаг агаарын зургийн баримтын хөмрөг, Хиймэл дагуулын баримтын хөмрөг, радарын баримтын хөмрөг, Автомат станцын мэдээний хөмрөг зэргээс бүрдэж байна. Нийт цаасан суурьтай баримтуудын 34.3% цахимжуулсан байна.


Ус, цаг агаар, орчны төлөв байдал, чанарын тоон мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр, хүртээмжтэй хүргэх ажлыг АЕГ-ын даргын 2023 оны А/68 тушаалаар батлагдсан үнэ тарифын дагуу мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санд орсон тоон мэдээгээр төр захиргааны байгууллага, иргэн аж ахуйн нэгж, оюутан, эрдэмтэй судлаачид, төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна /Зураг-1,2/. Жил дунджаар 303 хэрэглэгчид төлбөртэй мэдээний үйлчилгээ үзүүлж 48.6 сая төгрөгийн орлого төрийн санд төвлөрүүлж байна. 2019 онд 313 хэрэглэгчид 36 сая, 2020 онд 214 хэрэглэгчид 28 сая, 2021 онд 179 хэрэглэгчид 34 сая, 2022 онд 196 хэрэглэгчид 70 сая, 2023 онд 209 хэрэглэгчид 31 сая, 2024 онд 361 хэрэглэгчид 65 сая, 2025 онд 652 хэрэглэгчид 76 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Цахим засаглалыг хөгжүүлж, иргэдийг чирэгдэлгүй, шуурхай, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд <https://archive.weather.gov.mn/> цахим сайтыг хөгжүүлж хэрэглэгчдэд онлайн үйлчилгээ үзүүлж эхлээд байна. 2025 онд тус онлайн системээр 2073 хэрэглэгч хандаж 516 хэрэглэгч төлбөрий төлж мэдээний үйлчилгээг ямар нэгэн хүнээс үл хамаарсан байдлаар авсан байна. Онлай үйлчилгээгээр 12 сая төгрөгийн орлого бүрдсэн байна. Хэрэглэгчдэд e-barimt олгодог болов. Мөн И-Монголиа академитай хамтран хэрэглэгчийн мэдээний үйлчилгээ авах хүсэлтийг <https://service.e-mongolia.mn/dashboard> системээр дамжуулан авдаг болоод байна.

Жилийн нийт орлого/төгрөг/



Нийт хэрэглэгчдийн тоо, оноор



5.3. Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа

Ус цаг уурын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад орчин ихээхэн нөлөөтэй тул эдгээр орчин нөхцөлийг байнга хянаж, сайжруулж ажиллана. Үүнд:

Дотоод орчин:

Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг чанд мөрдөж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тавьж, хууль, тогтоомжид заасны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл ахиулах, дэвшин ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах;

Үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нийцсэн бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх;

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;

Мэргэжилтний ур чадвар, бүтээлч санаачилга, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх;

Үйл ажиллагааг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт гаргаж мөрдөх;

Байгууллага, хувь хүмүүс хоорондоо хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харилцан солилцох, ур чадвараасаа суралцах;

Газрын нэгж, харьяа байгууллагуудын ажлын уялдаа, холбоог сайжруулах;

Албан хаагч бүрд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлж, хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх;

Байгууллагын дотоодод мэдээлэл түгээх, харилцах цахим системийг боловсронгуй болгож, шуурхай, найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

Онцгой нөхцөл байдлын үеийн заавар, зөвлөмжийг дагуу шуурхай ажиллагааг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтын хэрэгжилтэд хяналт, дотоод аудит, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах;

Гадаад орчин:

Агентлагийн хувьд харилцагч талуудад чанартай үйлчилгээ үзүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй улс орон болон олон улсын

байгууллагын мэдээлэл, техник технологийн ололтоос суралцах, тэдгээрийг нэвтрүүлэх үүднээс гадаад орчноо тогтмол сайжруулан ажиллана.

Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх;

Төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Засгийн газрын бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэх зорилтыг хангах, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх;

Агентлагийн манлайлал, үйл ажиллагаа, үйлчилгээг харилцагч талууд, олон нийтэд ойлгуулан сурталчлах;

Мэдээллийг нээлттэй байлгах, харилцан солилцох;

Бодлогын баримт бичигт тусгагдсан 9 зорилт болон хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж ямар байгааг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан тодорхойллоо.

Дотоод орчны шинжилгээг хийхдээ салбарын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойллоо.

Гадаад орчны шинжилгээг хийхдээ УИХ, Засгийн газар, яамны бодлого чиглэл, салбарын техник технологийн чадавх, гадаад хамтын ажиллагааны зүгээс зорилтыг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргалаа.

**Цаг уур, орчны шинжилгээний газрын стратегийн зорилтуудад
хийсэн дотоод, гадаад орчны шинжилгээний
үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт**

Стратегийн зорилт 1. Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний 138 өртөө, 180 харуул, ус судлалын 154 харуул, 22 орчны шинжилгээний лаборатори, аэрологийн 4 өртөө ажиллаж байна. - Арга зүй, технологи хангалттай бий болсон. - Цаг уурын бодит ажиглалтын улсын сүлжээний 58% нь автомат хэмжих хэрэгслээр хэмжил гүйцэтгэж байна. - Хэмжилзүйн болон орчны хяналт шинжилгээний лабораторийг ажиллуулан сорилын болон хэмжлийн нэгдмэл байдлыг ханган ажиллаж байна. - Технологийн дотоод аудитыг хийж байна. - Ажиглалтын сүлжээг тасралтгүй 24 цаг ажиллуулах боломж бүрдсэн.	- Улсын сүлжээний нягтрал хангалтгүй - Цаг уурын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай. - Цаг уурын сүлжээний 42 хувь, ус судлалын харуул 100 хувь механик хэмжих хэрэгслээр хэмжил хийж байгаа нь хэмжлийн алдаа, тасралт үүсэх шалтгаан болж, хэмжлийн давтамж бага байна. - Техник, технологийн шинэчлэл жигд, хүртээмжтэй хийгдэхгүй байна. - Орон тоо, урсгал зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орны хувьд арга, зүй заавар зөвлөмжөөр байнга хангагдах. - Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд зарим салбарт техник технологийн шинэчлэлийг хийх. - Ус цаг уур, орчны шинжилгээний салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлэн тавьсан бодлогын зорилтууд - Улсын сүлжээний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжилт татах	- Монгол орны нийт нутаг дэвсгэрт дэд бүтэц жигд хөгжөөгүй. - Ус, цаг уурын ажиглалт, хэмжилд механик хэмжих хэрэгсэл ашигласаар байгаа. - ДЦУБ-ын зөвлөмж болон минаматагийн конвенцын хүрээнд мөнгөн уст хэмжих хэрэгслээс дэлхий нийтээр татгалзсан хэдий ч манай салбарт өргөнөөр ашиглагдаж байгаа. - Орчин үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын дутагдалтай. - Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн баталгаанаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчний дутагдалд орох хандлагатай.
Стратегийн зорилт 2. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх 46 экспедиц, газрын генератор ажиллаж байна. - Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлснээр ган зудын эрсдэл, хуурайшилтыг бууруулах болон ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. - Цаг агаарт зориудаар нөлөөлөх боловсон хүчнийг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж байна.	- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, арга зүй, технологийг сайжруулах шаардлагатай. - Орчин үеийн дэвшилтэд техникийн шинэчлэл хийх шаардлагатай. - Тэсэрч дэлбэрэх бодистой харьцах мэргэжлийн боловсон хүчний нөөц дутагдалтай.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- Хууль эрх зүйн орчин бүрдсэн. - Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд бусад орны туршлагыг судлах боломжтой болсон. - Цаг агаар зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны төрөл, хэлбэрүүд нэмэгдэж байна.	- Олон нийтийн дунд үйл ажиллагааны талаар буруу ойлголт бий болох - Тэсэрч дэлбэрэх бодистой харьцахдаа технологийн горим, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлаагүйгээс үүдэн хохирол гарах

- Хөрш орнуудад цаг агаарт нөлөөлөх үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаа	- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны пуужин, түлш хилээр нэвтрүүлэх, тээвэрлэхэд хүндрэлтэй байгаа
Стратегийн зорилт 3. Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээ, интернетийн хурдыг нэмэгдүүлэх.	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал - ОХУ-ын Новосибирск бүсийн төв болон Япон улсын цаг уурын байгууллагатай интернетэд суурилсан VPN сувгаар холбогдож мэдээлэл солилцож байна. - Мэдээлэл солилцооны MSS, GTS программ хангамжийг ашиглаж олон улсаас мэдээлэл /BUFR формат/-ийг хүлээн авах болон дамжуулах ажлыг гүйцэтгэж байна. - Хот хоорондын мэдээлэл солилцоонд Мэдээлэл холбоо сүлжээ ХК-ы шилэн кабелийг ашиглан 5mpbs хурдтай интернет, 3mpbs өргөнтэй VPN сувгийг ашиглаж байгаа бол төв байранд 80mpbs хурдтай интернетийг ашиглаж байна. - Хот хоорондын ус цаг уурын ажиглалтын мэдээлэл дамжуулалтад 2018 оноос эхлэн "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийг шинээр нэвтрүүлэн ашиглаж байна.	Сул тал - "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийн хэвийн ажиллагаа, дамжиж буй мэдээллийн ирц, чанарт тавих хяналт сул байна. - Ажиглалтын цэгээс мэдээллийг шууд хүлээн авах боломжийг бий болгох интернетийн найдвартай эх үүсвэр хангалтгүй. Төсвийн зардал хүрэлцэхгүй байна. - Хот хоорондын сувгийн өргөн, интернетийн хурдыг дамжуулж буй мэдээллийн багтаамжтай харьцуулахад илт бага байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байна. - Орон нутгийн УЦУОШТ-үүдийн холбоо, сүлжээний инженерүүдийн чадавх сул, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангахгүй байна.
ГАДААД ОРЧИН	
Боломж - Бээжингийн бүсийн төвтэй мэдээлэл солилцох сувгийг Интернетэд суурилсан VPN суваг болгон шинэчилснээр олон улсад мэдээлэл дамжуулах болон хүлээн авах хурд нэмэгдүүлэх. - BUFR форматтай мэдээллийг хүлээн авч боловсруулах, дамжуулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн програм хангамжийг нэвтрүүлэх. - Хот хоорондын сувгийн өргөн, интернетийн хурдыг нэмэгдүүлэх.	Эрсдэл - Хот хоорондын мэдээлэл солилцоонд ашиглаж буй холбоо сүлжээний шилэн кабель тасрахад мэдээлэл дамжуулах нөөц суваг байхгүй байна. - Олон улсаас хүлээн авч буй BUFR форматтай мэдээлэлд кодчлолын өөрчлөлт, шинэчлэлт ороход түүнийг тухай бүр MSS, GTS программ хангамжид өөрчлөлт оруулах, сайжруулах боломжгүй байна. - "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийн хэвийн аюулгүй ажиллагаа доголдсон тохиолдолд мэдээлэл хүлээн авах нөөц систем байхгүй байна.
Стратегийн зорилт 4. Ус цаг агаар, орчны урьдчилан мэдээлэх систем, мэдээлэл үйлчилгээний чанарыг сайжруулах	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал - ЗГ-ын 2015 оны 286-р тогтоолоор Сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээнд орох ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалтыг баталсан. - Ажиглалтын болон урьдчилан мэдээлэх системийн тасралтгүй 24 цаг ажиллуулах хүний нөөц бүрдсэн. - 2011, 2025 онд Суперкомпьютерын технологийг нэвтрүүлсэн нь урьдчилсан мэдээний чанар, таарцыг ахиулахад ихээхэн түлхэц болсон. - Аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх системийн суурь тавигдсан.	Сул тал - Ажиглалтын станц, харуулуудын орон зайн нарийвчлал 150км ээс их, ажиглалтын хоорондох хугацаа 3-8 цаг тул эдгээр үзүүлэлтээс бага орон зайд үүсээд, хөгжөөд сарнидаг үер, аадар бороо, аянга, цахилгаан зэрэг ус, цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлийг илрүүлэх боломж бага байна. - Цаг уурын доплерын радарын сүлжээ байхгүй - Ган, зуд зэрэг урт хугацааны аюултай үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх нь онолын хувьд ч, практикийн хувьд ч нэлээд хүндрэлтэй байдаг.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл

- ДЦУБ-аас чиглэл, зөвлөмж, зааварчилгаа өгдөг, сургалт явуулдаг. - Бусад улс орнуудын туршлагаас хуваалцах боломж байдаг. - Гамшгаас хамгаалах байгууллагатай хамтран ажиллах - Хиймэл дагуулын мэдээ ашиглах боломж нээлттэй. Хиймэл оюунд суурилсан шийдлүүд нэвтэрч байгаа	- Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж, агаар мандлын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэж, учрах хохирол нэмэгдсээр байна. - Хэрэглэгчдийн хүсэлт, шаардлага тасралтгүй нэмэгдэж байна. - Улс орны хөгжил, хотжилтын нөлөөгөөр хүний ам нас, эд хөрөнгө ус, цаг агаарын аюултай үзэгдэлд өртөх эрсдэл нэмэгдсээр байна. - Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж, шинэ технологийн нэвтрүүлэлт, технологийн шинэчлэлт мэдээллийн технологийн хурдтай зэрэгцэн хийгдэж чадахгүй байна.
Стратегийн зорилт 5. Хиймэл оюун ухаан, супер-компьютерийн технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг хөгжүүлж, орчны болон ус, цаг агаарын урьдчилсан мэдээг статистик, динамик загварт суурилан тооцоолон гаргах	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
- Ус, цаг агаар, уур амьсгал, орчны чиглэлийн богино, дунд, урт хугацааны прогноз, агаарын бохирдол, усны урсал, үерийн прогноз, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн тооцооны үр дүнгийн орон зайн нарийвчлал эрс сайжирна.	- Тухайн технологийг нэвтрүүлэхэд өртөг өндөр, техникийн засвар үйлчилгээг байнга хийх шаардлагатай. - Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд хугацаа ихээр шаарддаг.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- Монгол орны нийгэм, эдийн засгийн олон салбаруудын энэ чиглэлийн өнөөгийн хэрэгцээ, шаардлага ихсэж байгаа. - Өндөр хөгжилтэй орнуудад хөгжүүлэлтийг ихээр хийж байгаа	- Монгол улсын дэд бүтцийн хөгжлөөс шууд хамаарах - Цахилгааны тогтворгүй байдал, хөргөлтийн төхөөрөмжийн муу байдлаас болж суперкомпьютер болон төхөөрөмж гэмтэл гарах.
Стратегийн зорилт.6. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
- Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги, төлөвлөгөөний шинжлэх ухааны үндэс гарна.	- Олон салбарын судлаачид нөлөөллийн үнэлгээ хийх учир цаг хугацаа их шаардана.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээнд суурилан олон улсын санхүүжилт, донороос төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	- Салбарын судлаачдын уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлийн мэдлэг, боловсрол, үнэлгээ хийх арга дутмаг тул үнэлгээг хийхдээ алдаа гарах
Стратегийн зорилт 7. Ус, цаг уур, орчны мэдээ, мэдээллийн ажлын чанар, хүртээмжийг сайжруулахад тогтвор суурьшилтай чадварлаг мэргэшсэн хүний нөөцийг бий болгох	
ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
- Төрийн захиргааны төв байгууллагын хувьд улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нэгдсэн удирдлага зохион байгуулалттай, эрх зүйн орчин бүрдсэн. - Монгол орны 318 сум суурин газарт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлыг 1700 гаруй албан хаагчид гүйцэтгэж байна. - ДЦУБ болон бүсийн төвүүд, бусад орны цаг уурын байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна.	- Салбарын хууль нь орчин үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй, зохицуулах боломжгүй байна. - Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчин дутмаг - Нийгмийн хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх эдийн засгийн хөшүүрэг хуулиар нарийвчлан зохицуулаагүй - Цалин, нийгмийн хангамжаас шалтгаалан мэргэжлийн хүний нөөц хомсдолтой. - Төсөв санхүүгийн улмаас ДЦУБ-аас сургалт бусад үйл ажиллагаанд оролцож чадахгүй байна.

ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
- Шинэ техник, технологийн дэвшил нь хэрэглэгчдэд мэдээ, мэдээллийг хүргэх боломж бүрдсэн. - Шинэ зорилтот хэрэглэгчдийг бий болгох, тэдэнд хүрч ажиллах эрх зүйн орчин бий болгох - Төр хувийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан үр ашигтай ажиллах боломж олгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой. - Олон улсын байгууллагуудаас төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	- Тусгай хэрэгцээний мэдээ мэдээлэл гаргахад техник, технологийн шинэчлэл хийгдээгүй, хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад хоцрогдож байгаа. - Хууль эрх зүйн орчин тодорхойгүйгээс шалтгаалан санхүү, хөрөнгө, хүний нөөцийн хомсдол бий болох. - Дэлхийн улс орнуудын хөгжлийн хурд, технологийн дэвшлээс хоцрогдох - Салбарын эдийн засагт үзүүлж байгаа үр өгөөжийг үнэлэн санхүүгийн зөв механизм ажиллахгүй, тооцоо судалгааг ашиглахгүй шийдвэр гаргах.

Зургаа. Стратегийн зорилго:

Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангана.

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН
2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024)	Зорилтот түвшин (2025-2028)				Санхүүгийн эх үүсвэр сая.төг	Хэрэгжүүлэх нэгж, байгууллагууд
					2025	2026	2027	2028		
1		3	4	5	6	7	8	9	10	11
Ерөнхий чиг үүргийн нэр: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ										
Үндсэн чиг үүрэг-1: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах										
1	Зорилт-1 Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх.	1. Суперкомпьютерийг шинэчлэх	1. Шинэ Суперкомпьютерийг суурилуулсан эсэх	1	1. Супер компьютерийг суурилуулсан байна.	2.10	2.10	2.10	4.500 ЗТ	ЦУОШГ НҮБХХ
2		2. Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Радарын байгуулах	2. Сургалтад хамрагдсан инженерийн тоо	1					УТ, БЭУ	ЦУОШГ, УЦУОШТ-УУД
3		3. Ус судлалын харуулыг автоматжуулах	Автоматжуулах усны харуул, өссөн тоогоор	-	17	-	20	20	УТ, БЭУ	ЦУОШГ, УЦУОШТ-УУД
4		4. Цаг уурын өртөө, харуулуудад цаг уурын автомат станц суурилуулах	Шинээр суурилуулах автомат станц, тоо	215	4	4	20	20	УТ, БЭУ	ЦУОШГ, УЦУОШТ-УУД
5		5. Аймгийн нисэх буудлуудад нисэхийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай нөөц	Суурилуулсан нөөц автомат станцын тоо	-	-	5	5	5	500,0 УТХО	ЦУОШГ НЦУТ УЦУОШТ-УУД

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
		автомат суурилуулах	станц							
6		6.Чингис хаан ОУНБ-д салхины шилжлэг илрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	Тоног төхөөрөмжийн тоо	0	-	1	-	-	8.000,0	ЦУОШГ НЦУТ
7		7.Бусчилсан хэргийн бодлогын хүрээнд бүсийн төвийн лабораторийг бий болгож нарийн хэмжлийн багажаар хангах	Нарийн хэмжлийн багаж суурилуулсан лабораторийн тоо,	0	-	-	1	2	4.500,0	БОУАӨЯ ЦУОШГ БОХЗТЛ
8		8.Байгаль орчны шинжилгээний лабораторийн чадавхжуулах хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт, хувь	-	-	50	100	-	ГЗТ	БОУАӨЯ ЦУОШГ БОХЗТЛ
9		9. БОХЗТЛ болон орон нутгийн орчны хяналт шинжилгээний лабораториудыг итгэмжлэлд хамруулах	Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн тоо	15	-	-	18	22	УТ-УЗ	ЦУОШГ, БОХЗТЛ, УЦУОШТ- УУД
10		10.УБ хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын суурин станц суурилуулж 3-6 үзүүлэлтийг автоматаар тодорхойлох	1.Автомат станцын тоо	0	21	-	-	-	Зээл туслам ж	ЦУОШГ, БОХЗТЛ, УЦУОШТ- УУД
11		11.БОХЗТЛ болон 21 аймгийн БОШЛ-ийг агаараас тоосонцорын сорьц авах багажаар хангах	Багажийн тоо,	2	-	-	11	21	ГЗТ	ЦУОШГ, БОХЗТЛ, УЦУОШТ- УУД
12		12.Орон нутгийн БОШЛ-ийн байрыг өргөтгөх	Лабораторийн тоо	0	-	1	-	-	УТ	ЦУОШГ, УЦУОШТ- УУД
13		13.Агаарын чанарын явуулын лабораторийг ашиглах	Лабораторийн тоо	0	-	1	--	-	ГЗТ	ЦУОШГ, БОХЗТЛ,

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
14		14.Аэрологийн өртөөдийн хөөргөлтийн нэмэгдүүлэх	Аэрологийн өртөөний тоо	4	-	6	-	-	ГЗТ	ЦУОШГ,
15		15.Тусгай зориулалтын цаг уурын автомат станцуудыг суурилуулах, мэдээллийг үндэсний сүлжээнд оруулж, улсын сүлжээг өргөтгөнө.	Тусгай хамгаалалтай газар болон цахилгаан холбооны дахин дамжуулах сүлжээ станцуудад) Автомат станц суурилуулсан тоо	0	-	-	5	5	ГЗТ	ЦУОШГ,
17		17.Устөрөгч гарган авах технологийг шинэчлэх	Шинэ технологи нэвтрүүлсэн аэрологийн өртөөний тоо	-	2	-	2	1	УТ ГЗТ	ЦУОШГ
18		1.Мөндөр сарниулах шинэ технологи нэвтрүүлэх,	Үйл ажиллагааны явц %	0	-	50	100	-	УТ	ЦУОШГ
19		2.Манан сарниулах шинэ технологи нэвтрүүлэх	Үйл ажиллагааны явц %	0	-	-	50	100	УТ	УЦУОШТ
20	Зорилт-2. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны өгөөжийг нэмэгдүүлэх	3.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг мөндөр, манан сарниулах чиглэлд өргөжүүлэх хүрээнд явуулын радар, шинэ газрын генератораар хангах	1. Шинээр байгуулах явуулын радарын тоо, 2. Газрын генератор, тоогоор	-	-	1.1 2.2	1.2 2.5	-	УТ	ЦУОШГ УЦУОШТ- үүд
21		4.Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааны тооцох боловсруулах	Хэрэгжилтийн явц	-					ГЗТ	ЦУОШГ
22	Зорилт-3. Мэдээлэл	1.Улаанбаатар хотын газруудын харьяа	Интернетиин хурд мВ	100	120	150	-	180	УТ	ЦУОШГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах	интернэтийн нэмэгдүүлэх 2. Орон нутгийн интернэтийн хурдыг нэмэгдүүлэх	Интернэтийн хурд mB	8	16	-	32	-	УТ	ЦУОШГ
23		3. Цаг уурын мэдээллийн системийг WIS 2.0-д шилжүүлэх	Хэрэгжилтийн явц	0	-	30	30	90	УТ	ЦУОШГ
24		4. Олон улсын мэдээлэл солилцоонд өртөөний тоог нэмэгдүүлэх	Өртөөний тоо	63	138	-	-	-	УТ	ЦУОШГ
25		5. Шөнийн хугацааны ажиглалтын мэдээллийг автоматаар кодлож дамжуулах	Хэрэгжилтийн хувь	0	100	-	-	-	УТ	ЦУОШГ
26										
Үндсэн чиг үүрэг -2 : Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах										
27		1. Олон төрлийн гамшигт үзэгдлээс сэргэмжлүүлэх, эртнээс суурилсан систем болгон хөгжүүлэх, нэвтрүүлэх	Систем нэвтрүүлэх шат, хувь	Төслөөр туршилт судалгаа хийгдсэн	-	30	60	100	УТ ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
28	Зорилт 4. Ус цаг агаар, орчны урьдчилан мэдээлэх систем, мэдээлэл үйлчилгээний чанарыг сайжруулах	2. Эрт сэргэмжлүүлгийн хүртээмжийг сайжруулахад технологийн дэвшлийг ашиглах /E-mongolia, app, үүрэн холбооны технологийн боломж/	Түгээж буй хэлбэрүүд	ГЯЛС апп болон уламжлалт хэрэгслээр хүрч байна.	-	E-mongolia, app, үүрэн холбооны технологийн боломж уудаар хүргэдэг болсон байна			УТ ГЗТ	ЦУОШГ
29		3. Хиймэл оюун ухаант Ус цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийг	Нэвтрүүлэх шат, хувь	0	-	30	60	100	УТ ГЗТ	ЦУОШГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
		урьдчилан мэдээлэх систем нэвтрүүлэх								
30		4.Цаг агаарын дунд хугацааны прогнозын чанарыг тасралтгүй сайжруулах	5 хоногийн урьдчилсан мэдээний таарц, хувь	87.9	88.1	88.4	88.6	88.9	УТ	ЦУОШГ
31		5.Байгаль орчны мэдээллийн сангийн нэгдмэл байдлыг хангаж мэдээллээр баяжуулах, цахим үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх	Төрөлжсөн мэдээллийн сангийн тоо	42	44	46	50	54	УТ ГЗТ	БОАЖЯ ЦУОШГ УЦУОСМХ
32		6.Байгаль орчны мэдээллийн сангийн дэд системүүдийг E-Mongolia, ХУР, DAN төрийн нэгдсэн системтэй холбох	E-Mongolia-д холбогдсон байдал хувиар	0	25	50	75	100	УТ ГЗТ	БОАЖЯ ЦУОШГ УЦУОСМХ
33		7.Ус цаг уурын горимын мэдээллийн сангийн нэгдмэл байдлыг хангаж, мэдээллээр баяжуулах, цахим үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх	Горимын мэдээллийн сангийн тоо	1					УТ	БОАЖЯ ЦУОШГ
34		8.Ус цаг уур, орчны төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдмэл байдлыг хангаж, мэдээллээр баяжуулах, цахим үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх	Төрөлжсөн мэдээллийн сангийн тоо	1					УТ	БОАЖЯ ЦУОШГ
35		9.Байгаль орчны шинжилгээний лабораториудад цахим бүртгэл, мэдээллийн систем нэвтрүүлэх	Хэрэгжилтийн хувь	0	25	50	75	100	Улсын төсөв	ЦУОШГ БОХЗТЛ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
36		10. Нислэгт зориулсан бүх төрлийн цаг уурын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах	Хэрэгжилтийн хувь	0	25	50	75	100	Улсын төсөв	ЦУОШГ НЦУТ
Үндсэн чиг үүргийн нэр: Ус цаг уур, орчны эрдэм шинжилгээ, судалгаа хийх										
37	Зорилт 5. Суперкомпьютерийн технологийг суурилсан орчны болон ус, цаг уур, агаарын урьдчилсан мэдээг статистик, динамик загварт суурилан тооцоолон гаргах	1. Бүс нутгийн цаг агаарын тоон загварыг орон зай, цаг хугацааны нарийвчлалыг сайжруулах.	1. Орон зайн нарийвчлал 2. Хугацааны урьдчилал	5км, 5 хоног	-	-	1.1-3 2.10	-	УТ-УЗ	УЦУОСМХ
38		2. Ус, цаг агаар, орчны гамшигт үзэгдлийн машин сургалтын аргахиймэл оюун ухаанд суурилсан загварчлалыг хөгжүүлэх	Мэдээллийн сан, технологи	-	-	Шуурхай мэдээллийн сан байгуулах,	Технологий боловсруулах	-	УТ-УЗ	УЦУОСМХ
39		3. Цаг агаарын урьдчилсан мэдээний урьдчиллыг нэмэгдүүлж, хугацааны нарийвчлалыг сайжруулах	Урьдчилал, хугацааны нарийвчлал, цаг	5 хоног 12 цаг	-	10 хоног 3цаг	-	-	УТ-УЗ	ЦУОШГ
40		4. Сар улирлын прогнозад дэлхийн хэмжээний загварын системийг нэвтрүүлэх	1. Орон зайн нарийвчлал 2. Хугацааны урьдчилал	200км, 30 хоног	-	-	1.30-50 км, 2.45 хоног	-	УТ-УЗ	УЦУОСМХ
41		5. Таримал болон бэлчээрийн ургамлын ургацын динамик прогнозыг гаргах	1. Хугацааны урьдчилал 2. Станцын тоо	-	-	-	1.10 хоног 2.21 станц	-	УТ-УЗ	УЦУОСМХ
42		6. Гол мөрөн үерийн динамик прогнозыг гаргах	1. Хугацааны урьдчилал 2. Станцын тоо	-	-	-	1.10 хоног 2.21 станц	-	УТ-УЗ	УЦУОСМХ
43		7. Гангийн мониторинг системийг хөгжүүлэх	1. Индекс 2. Орон зайн нарийвчлал	-	-	1 шинэ индекс, 2.200м	-	-	ЗТ	УЦУОСМХ
44		8. Хэт богино хугацааны урьдчилан мэдээлэх	Нэвтрүүлсэн байдал, хувь	үгүй	-	10	50	100	Улсын төсөв	ЦУОШГ УЦУОСМХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
		технологийг хөгжүүлэн нэвтрүүлэх								
45		9.Ус, цаг агаарын аюултай үзэгдлийн сэрэмжлүүлгийн чанарыг сайжруулах	Сэрэмжлүүлэгийн онч, хувь	80.1	80.5	82.5	83.5	85.5	Улсын төсөв	ЦУОШГ
46		10.Агаарын чанарын урьдчилсан мэдээний хамаарлыг сайжруулах	Урьдчилсан мэдээний хамаарал, хувь	65%	70	75	80	85	Улсын төсөв	ЦУОШГ
47		11.Гол мөрний дундаж урсац, үерийн урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх	Урьдчилсан мэдээний таарц, хувь	70%	72.5	75	77.5	80	Улсын төсөв	ЦУОШГ УЦУОСМХ
48		12.Хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх	Урьдчилсан мэдээний таарц нэмэгдсэн, хувь	1.65 2.14	-	1.68 2.16	1.72 2.18	1.75 2.20	Улсын төсөв	ЦУОШГ УЦУОСМХ
49		13.Хиймэл дагуул, радар, дроны мэдээг боловсруулж, ассимиляци хийн, шинэ арга, технологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аргын тоо,	-	-	-	2	3	Улсын төсөв	ЦУОШГ УЦУОСМХ
50		14.Хиймэл оюун ухаан ашиглаж урьдчилан мэдээлэх арга, загвар нэвтрүүлэх	Аргын тоо	1	-	1	1	3	Улсын төсөв	ЦУОШГ УЦУОСМХ
51	Зорилт-6. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх	1.Бүсийн уур амьсгалын өөрчлөлт, өнөө болон ирээдүйн хандлагын судалгаа, загварчлалыг нарийвчлах	1.Хүлэмжийн хувилбарууд 2.Орон зайн нарийвчлал	-	-	-	1.Их, бага, дунд хувилбарууд, 2. 10 км	-	УТ-УЗ	УЦУОСМХ
52		2.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдлын үнэлгээг нарийвчлан гаргах	Судалгааны үр дүн, тайлан Усны нөөц, мал ажуй, газар тариалан,	-	-	-	1	-	УТ-УЗ	УЦУОСМХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
			гамшиг, дэд бүтэц /							
53		3.Монгол орны уур амьсгалын атласыг шинэчлэн боловсруулах	Атласын тоо	-	-	1	-	-	УТ-УЗ	УЦУОСМХ
Ерөнхий чиг үүргийн нэр: Ус цаг уур, орчны шинжилгээ										
Үндсэн чиг үүргийн нэр: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах										
54		1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийг шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	Хэрэгжилтийн хувь	-	20	100	-	-	Улсын төсөв	ЦУОШГ
55		2.Салбарын холбогдох албан хаагчдыг амь насны даатгалд хамруулах	Амь насны даатгалд хамруулсан албан хаагчдын тоо,	195	-	295	385	480	Улсын төсөв	ЦУОШГ
56		3.Албан хаагчдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах төсвийг нэмэгдүүлэх	Хангалтын төсөв, сая төгрөг	9.3	-	-	25	30	Улсын төсөв	ЦУОШГ
57		4.Дотоодын болон олон улсын сургалтад хамруулах	Мэргэшүүлэх сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	130	-	145	165	180	Улсын төсөв	ЦУОШГ
58		5.Бакалавр, магистр докторын сургалтад тэтгэлгээр суралцуулах	Тэтгэлэг олгосон суралцагчдын тоо	0	-	-	5	5	Улсын төсөв	ЦУОШГ
59		1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтын хэрэгжилтэд хяналт, дүгнэлт, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах	Хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн тоо	-	-	2	5	8	Улсын төсөв	ЦУОШГ
60		2.Хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, тавих,	Хяналт, үнэлгээ, дотоод аудит	-	-	2	5	8	Улсын төсөв	ЦУОШГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	үнэлгээ өгөх	үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах	хийж, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргасан тоо							
61		3.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод аудит, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх	Төсвийн төвлөрүүлэн захирагчийг эрсдэлийн удирдлагаар хангаж гаргасан зөвлөмжийн тоо	-	-	2	5	8	Улсын төсөв	ЦУОШГ

Найм. Стратегийн зорилго ба Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Монгол Улсын хэмжээнд цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээ хийх, ус, цаг агаар, орчны төлөв байдал, чанарын талаарх мэдээллээр шуурхай үйлчлэх үйл ажиллагааг зохион байгуулж, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх үүрэгтэй төрийн захиргааны байгууллага болно.

Тус газрын Стратегийн зорилго нь “Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөр”-т тулгуурлан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Энэхүү стратегийн зорилгыг болон Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/692 дугаар тушаалаар батлагдсан “Цаг уур, орчны шинжилгээний газрын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн дагуу 70 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус газар болон харьяа 25 байгууллагад нийт 1722 албан хаагч ажиллаж байна.

Тус агентлаг нь 2 газар, 5 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөнд тусгасан стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд одоогийн бүтэц нийцэж байгаа болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах” үндсэн чиг үүргийн хүрээнд дэвшүүлсэн 1,2,3 дугаар стратегийн зорилтуудыг Улсын сүлжээний газар, Технологи инновацын хэлтэс тус тус удирдан зохион байгуулж, Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв болон Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд хамтран хэрэгжилтийг ханган ажиллана. Мөн тус төлөвлөгөөний “Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах” үндсэн чиг үүргийн хүрээнд дэвшүүлсэн 4, 5, 6 дугаар зорилтуудыг Урьдчилан мэдээлэх газар, Архив мэдээллийн сангийн хэлтэс, Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтэс тус тус удирдан зохион байгуулж, Ус цаг уур, судалгаа мэдээллийн хүрээлэн хамтран хэрэгжилтийг ханган ажиллана.


Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тус газрын Захиргааны хэлтэс зохион байгуулж ажиллах бөгөөд Цаг уур, орчны шинжилгээний салбарыг захиргааны нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, манлайллыг хөгжүүлэх, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, салбарын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, хөгжүүлэх үүрэг хүлээн ажиллана.

Энэхүү стратегийн зорилтуудыг бүхэлд нь хэрэгжүүлэхэд тус байгууллагын бүтцийн бусад нэгжүүд хамгийн чухал үүргийг гүйцэтгэх бөгөөд салбарын төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулах, тайлагнахад хяналт тавих, санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх; олон улсын гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хөтөлбөр, төслийг санаачлах, боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах, гадаад хамтын ажиллагааны богино, дунд, урт хугацааны стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, гадаад түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сургалт, семинар, уулзалтын зохион байгуулах, салбарын бодлого төлөвлөлт, хууль тогтоомж, холбогдох хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж

байгаа төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг зайлшгүй шаардлага үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.1 Цаг уур, орчны шинжилгээний газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр (Бүтцийн схем 1)

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч болон үйлчлүүлэгчийн бүлгийг доорх зурагт тусгаж, тэдэнд үзүүлэх үйлчилгээг бүлэг хэрэглэгчээр тодорхойлов.



8.2 Цаг уур, орчны шинжилгээний газрын бүтэц, зохион байгуулалт
(Бүтцийн схем 2)



Тус агентлагийн харьяа Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь ус, цаг уур, байгаль орчны хувьсал өөрчлөлтийн төлөв байдлыг үнэлэх, Монгол орны нутаг дэвсгэр дээрх уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уур, гадаргын усны горим, нөөцийн зүй тогтлыг илрүүлэн тогтоох, байгалийн нөөцийг улс орны бүхий л салбарт зүй зохистойгоор

ашиглуулах, байгаль, цаг уур, гадаргын ус судлал, байгаль орчны тандан судалгаа, уур амьсгал, орчны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнг нь үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ өгөх үүрэг бүхий салбарын тэргүүлэх эрдэм шинжилгээний, төрийн үйлчилгээний байгууллага.

Агаарын хөлгийн нислэг, хөдөлгөөний аюулгүй байдал, түүний эдийн засгийн үр ашиг олон зүйлээс хамаарах боловч тухайн газар, орны уур амьсгал, цаг уурын нөхцөл онцгой нөлөө үзүүлнэ. Иймээс агаарын хөлгийн нислэг хөдөлгөөнийг цаг агаарын байдалтай уялдуулан зохицуулахад онгоц хөөрөх, буух, аэродром орчмын болон нислэгийн замын дагуух цаг агаарыг урьдчилан мэдээлэх шаардлагатай байдаг. Энэ үүргийг Нислэгийн цаг уурын төв /НЦУТ/ 1967 оноос хойш бие даан дагнан гүйцэтгэж байна.

Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори нь Монгол орны хэмжээнд байгаль орчны чанарт хяналт тавих, цаг уурын шинжилгээний хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах, шинэ хэмжих хэрэгслийг төв орон нутагт байрлуулах, тэдгээрийн үзлэг үйлчилгээг хийх, шинжилгээний зарим тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх зэрэг төрийн үйлчилгээг үзүүлэх төв байгууллага бөгөөд байгаль орчны шинжилгээний хэлтэс, хэмжил зүйн хэлтэс, захиргаа аж ахуйн хэлтэс гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Байгаль орчны шинжилгээний хэлтэс нь агаар, ус, хөрс, цацрагийн лаборатори, хэмжилзүйн хэлтэс нь дотроо агаарын даралтын, нарны цацраг судлалын, чийг температурын, усны урсгалын хурд хэмжүүрийн, уртын хэмжлийн гэсэн лабораториудтай.

Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд нь тухайн аймгийн хэмжээнд Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангаж ажилладаг. Энэхүү чиг үүргийн хүрээнд ус цаг уурын улсын сүлжээний нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уур, гадаргын усны анхан шатны ажиглалт хэмжлийн үр дүнг боловсруулах, дамжуулах, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Мөн өөрийн аймгийн хэмжээнд цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээгээр үйлчилж, нислэгийн аюулгүй байдлыг ханган ажилладаг

Ес. Хавсралт

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/692 дугаар тушаал “Цаг уур, орчны шинжилгээний газрын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”–12 хуудас.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/180 дугаар тушаал–1 хуудас
- Мандатын шинжилгээний хүснэгт
- Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт

Товчилсон нэрийн тайлал:

ЦУОШГ
УЦУОСМХ
НЦУТ
БОХТЛ

Цаг уур, орчны шинжилгээний газар
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
Нислэгийн цаг уурын төв
Байгаль орчин, хэмжилзүйн төв лаборатори

УЦУОШТ
АНЗДТГ

Ус цаг уур, орчны шинжилгээний төв
Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

УТ - ХО
УТ - УЗ
ОНТ
ГЗТ
БЭУ

Улсын төсвийн хөрөнгө оруулалт
Улсын төсвийн урсгал зардал
Орон нутгийн төсөв
Гадаадын зээл, тусламж
Бусад эх үүсвэр

----oOo----